



ӨДРӨӨР ӨСӨЖ БУЙ SU БИЗНЕСТ ТАВТАЙ МОРИЛ

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Үнэт цаас гаргагч



Үндсэн андеррайтер



Туслах андеррайтер





Nice to CU

EXIT



ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО, МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИД ҮНЭТ ЦААСЫГ БҮРТГЭСЭН НЬ АЛИВАА ЭРСДЭЛЭЭС ХАМГААЛАХ БАТАЛГАА БИШ БОЛОХЫГ АНХААРНА УУ. ЭРХЭМ ТА ҮНЭТ ЦААС ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ЭРСДЭЛТЭЙ ҮЙЛДЭЛГЭДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, ТУХАЙН ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, ЗАХ ЗЭЭЛД ҮНЭТ ЦААС ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛЖ ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.

ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУД

Үндсэн андеррайтер



Голомт Капитал ҮЦК ХХК
info@golomtcapital.com
+976-7012 1530
www.golomtcapital.mn

Туслах андеррайтер



Апекс Капитал ҮЦК ХХК
investment@apex.mn
+976-7510 7500
www.apex.mn

Аудитын компани



БДО Аудит ХХК
+976-7740 4040
+976-7012 1530
www.bdo.mn

Хуулийн фирм



Өмгөөллийн Батбаяр Энд Партнэрс ХХН
contact@bnp.mn
+976-7012 1530
+976-7711 9008

Үнэлгээний компани



Гэрэгэ Эстимэйт ХХК
gantulga@geregepartners.mn
+976-9910 7317
+976-7000 5000

Байгаль орчин, нийгмийн засаглалын үнэлгээний компани



Ризилиенс Консалтинг Сервиз ХХК
nyamgarav@rcs.mn
+976-8810 4587

ҮНЭТ ЦААСНЫ ХУРААНГУЙ ТАНИЛЦУУЛГА

Нийтэд санал болгох эзэмшлийн хувь

15%

Нийт татан төвлөрүүлэх дүн

24,952,940,480
төгрөг

Нэгж хувьцааны үнэ

208 төгрөг

Үнэт цаасны төрөл

Энгийн хувьцаа

Нийт гаргасан хувьцааны тоо ширхэг

679,807,674

Олон нийтэд санал болгож буй
хувьцааны тоо ширхэг

119,966,060

Олон нийтэд санал болгосны дараах
хувьцааны тоо ширхэг

799,773,734

Хувьцааг арилжаалах арга

Тогтоосон үнийн
арга

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ



Хөрөнгө оруулагч таны энэ өдрийн амгаланг айлтгая.

Өнгөрсөн гуч гаруй жилд Монголчуудын амьдралын хэв маяг багагүй өөрчлөгджээ. Бидний өдөр тутмын амьдралын хэмнэл улам цаг завгүй, хурдтай болон өөрчлөгдөж байна. Ийм ч учраас бид өнөөдрийн Монголчуудын амьдралын хэв маягт тохирох үргэлж нээлттэй байдаг, хаанаас ч олж болох, чанартай бүтээгдэхүүн, соёлтой үйлчилгээтэй дэлхийн стандартын конвинеенс дэлгүүрийн сүлжээг Монголдоо байгуулах шийдвэрийг эдүгээгээс 4 жилийн өмнө гаргаж, дэлхийн шилдэг брэндүүдийн нэг болох БНСУ-ын "CU" конвинеенс дэлгүүрийн мастер франчайзийн эрхийг авч өнөөдрөөс 3 жилийн өмнө анхны "CU" дэлгүүрээ Улаанбаатар хотод нээж байлаа. Тэгвэл өнөөдөр бид 127 салбар дэлгүүртэй, өдөр бүр 38 мянган хүнд үйлчилдэг, Улаанбаатарчуудын өдөр тутмын амьдралын салшгүй нэг хэсэг болон өргөжин тэлжээ.

Бид аливаа бизнесийн амжилттай оршин тогтнох үндэс нь нийгэмдээ бүтээж буй үнэ цэнээр тодорхойлогддог гэдэгт итгэдэг. Сүүлийн 3 жилийн хугацаанд нээсэн салбар дэлгүүрүүдийн борлуулалт өсөж, үнэнч үйлчлүүлэгчдийн тоо өдрөөс өдөрт нэмэгдсээр байгаа нь бидний нийгэмдээ бүтээж буй үнэ цэний баталгаа гэж бид үздэг.

Дэлхийн жишиг болсон соёлтой, шуурхай бүтээгдэхүүн үйлчилгээгээр хэрэглэгчдийнхээ өдөр тутмын амьдралыг илүү жаргалтай болгож, дэлгүүр бүрээ инээмсэглэл, эелдэг харилцаагаар дүүргэхийг эрмэлздэг. Үүний тулд ажилтан албан хаагчдаа дэлхийн жижиглэн худалдааны тэргүүний туршлага, ур чадварыг эзэмшүүлж, олон улсын шилэгдмэл нөү хауг эх орондоо нутагшуулж, жижиглэн худалдааны салбарыг шинэ түвшинд хүргэхээр ажиллаж байна.

Мөн бид "CU" -ийн шилдэг туршлагаас суралцаад зогсохгүй, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг эх орондоо татсанаар Монголынхоо брэнд бүтээгдэхүүнийг CU-ийн олон улсын 15,000 гаруй салбар дэлгүүрт экспортлох үүд хаалгыг нээгээд байна.

Жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих, тэдний бизнесийн тогтвортой байдлыг хангах зорилгоор бид франчайз хөтөлбөр хэрэгжүүлдэг бөгөөд өнөөдөр 23 жижиг дунд бизнес эрхлэгчидтэй хамтран салбар дэлгүүрүүдээ ажиллуулж байна. Нөгөө талдаа хүнсний үйлдвэрлэл эрхэлдэг жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжин, тэдэнтэй хамтран бүтээгдэхүүнийг нь хөгжүүлж, өөрийн түгээлт, борлуулалтын сувгаараа дамжуулан 127 салбар дэлгүүрээрээ түгээн борлуулж байна. Мөн манай байгуулсан борлуулалт түгээлтийн дэд бүтцийг ашиглан дотоодын 300 гаруй бэлтгэн нийлүүлэгч бараа бүтээгдэхүүнээ хэрэглэгчдэд хүргэдэг.

Манай дэлгүүрийн сүлжээ нь зөвхөн шуурхай, соёлтой үйлчилгээний цэг биш, орчин тойрондоо буй иргэдийн өдөр тутмын амьдралын түшиг тулгуур, нийгмийн дэд бүтэц болон хөгжихийг бид зорьдог. Өнөөдөр бид нийтийн ариун цэврийн өрөөгөөр үнэ төлбөргүй үйлчлүүлэх, аюул осол тохиолдсон үед аюулгүй байдлаа хангуулах, халуун хүйтэнд амсхийх цэг зэрэг боломжуудыг олон нийтэд санал болгож, замын ачаалал бага үеэр барааны түгээлтээ зохион байгуулж Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулахад ч хувь нэмрээ оруулж байна.

Бид үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн өндөр боловсролтой, ур чадвартай, зөв хандлагатай залуусыг багтаа нэгтгэж тогтвортой орлого олох боломжоор хангадаг. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэднийг тэгш боломжоор ханган нийгмийн оролцоог нь нэмэгдүүлдэг. Энэ нь амжилтын маань нэг үндэс бөгөөд бидний бүрэлдүүлсэн хамт олон манай өрсөлдөх чадварын илэрхийлэл, компанийн хамгийн үнэ цэнтэй хэсэг нь билээ. Ийм ч учраас цаашид тэмүүлж буй зорилгодоо хүрч чадна гэдэгт итгэлтэй байдаг.

Ирээдүйд олон жилийн турш тогтвортойгоор үнэ цэн нь өсөх Сэнтрал Экспресс Си Ви Эс компанийн хувьцааг та бүхэнд нээлттэй санал болгож байгаадаа миний бие туйлын баяртай байгаа бөгөөд цаашид Монгол Улсын хөгжилд хувь нэмрээ хамтдаа оруулахыг хүсэж байна.

CU-д ТАВТАЙ МОРИЛ!

А.Ганхуяг
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Дарга





ТАВТАЙ МОРИЛ

ҮНЭТ ЦААС
ГАРГАГЧИЙН
ТУХАЙ

КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

Өдгөө Улаанбаатар хотын иргэдийн амьдралын салшгүй хэсэг болж өргөжин тэлж буй Сэнтрал Экспресс (CU) төслийг 2015 онд Премиум Групп эхлүүлж, Монгол Улсад конвениенс сүлжээ дэлгүүрийн анхны шавыг тавьсан. Улмаар 2017 онд Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийг үүсгэн байгуулснаар хэрэглэгч ая тухтай орчинд, өөрийн бүхий л хэрэгцээг нэг дороос хангах боломжтой сүлжээ дэлгүүрийн бизнес загварыг Монгол Улсад анх удаа нэвтрүүлсэн юм.


Үнэт цаас гаргагч нь 2018 оны 4 сарын 17-ны өдөр Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ)-ын БиЖиЭф Ритэйл Ко., ЭлТиДи (BGF Retail Co., Ltd.) компанитай тус улсын CU олон улсын конвениенс сүлжээ дэлгүүрийг Монгол Улсын жижиглэн худалдааны салбарт нэвтрүүлэх Мастер франчайзийн гэрээг албан ёсоор амжилттай байгуулсан юм.

Эдүгээ CU конвениенс сүлжээ дэлгүүр нь дан ганц дэлгүүр биш түгээлтийн систем, хоол үйлдвэрлэл, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, мэдээлэл технологийн шийдэл, нийгмийн дэд бүтэц зэргийг багтаасан цогц систем болон хөгжсөнийг онцлууштай.




ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД


Салбарын тоо




CU апп хэрэглэгчдийн тоо (мянга)



Нэг сарын үйлчлүүлэгчдийн тоо (мянга)



Борлуулалтын орлого (тэрбум төгрөгөөр)



2021 оны 6 сарын 30-ны байдлаар



Дэлгүүр
127



Ажилчид
1,200



CU апп хэрэглэгч
320,000



Өдрийн үйлчлүүлэгч
38,000



Өдрийн борлуулалт
320 сая




Онлайн борлуулалт
8 сая

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

Сэнтрал Экспресс Си Ви Эс компанийн үүсгэн байгуулагч, анхны хувьцаа эзэмшигч нь Премиум Групп юм. 2021 онд Премиум Групп нь охин компани болох Сэнтрал Экспресс Си Ви Эс компанийн энгийн хувьцааг Премиум Группийн эцсийн өмчлөгч 8 хувь хүнд шууд эзэмшүүлэхээр шилжүүлсэн. Улмаар Сэнтрал Экспресс Си Ви Эс компанийн эцсийн өмчлөгчдийг олон нийтэд ил, ойлгомжтой болгох, компанийн засаглалыг сайжруулах, сонирхлын зөрчилтэй аливаа үйлдлээс зайлсхийх нөхцөл бүрдсэн.

Одоогоор Сэнтрал Экспресс Си Ви Эс компанийн хувь эзэмшлийн 90.01 хувийг Премиум Группийн хувьцаа эзэмшигчид болох 8 Монгол Улсын иргэд хувь хүн, 9.99 хувийг БНСУ-ын БиЖиЭф Ритэйл Ко., ЭлТиДи эзэмшдэг. Компанийн тодорхой хувийг олон улсын туршлагатай сүлжээ дэлгүүрийн бизнес эрхлэгч эзэмших нь компанийн менежмент, үйл ажиллагааны стандарт, ирээдүйн өсөлтөд чухал нөлөөтэй.

Компанийн бүтэц



Компанийн хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл

Хувьцаа эзэмшигчдийн нэр	Эзэмшиж буй энгийн хувьцааны тоо	Нэгж хувьцааны нэрлэсэн үнэ (төгрөг)	Эзэмшиж буй энгийн хувьцааны нийт үнэ (төгрөг)	Эзэмшиж буй хувь хэмжээ
А.Ганхуяг	235,540,889	100	23,540,888,900	34.64%
А.Ганболд	172,327,784	100	17,232,778,400	25.35%
Ц.Баяржаргал	88,164,258	100	8,816,425,800	12.97%
А.Одончимэг	32,304,463	100	3,230,446,300	4.75%
А.Ганбаатар	31,248,463	100	3,124,846,300	4.60%
О.Батмөнх	19,731,751	100	1,973,175,100	2.90%
Г.Бат-Эрдэнэ	19,731,751	100	1,973,175,100	2.90%
Ө.Мөнхбаяр	12,909,548	100	1,290,954,800	1.90%
БиЖиЭф Ритэйл Ко., ЭлТиДи	67,980,767	100	6,798,076,700	9.99%
Нийт	679,807,674	100	67,980,767,400	100%

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ ПРЕМИУМ ГРУППИЙН ТУХАЙ



PREMIUM
Group

Премиум Групп нь Монгол Улсын барилга, дэд бүтэц болон жижиглэн худалдааны салбарт тэргүүлэгч аж ахуйн нэгжийн хувьд бизнесийн бүхий л үйл ажиллагаандаа орчин үеийн дэвшилтэт технологид суурилсан бизнесийн шийдлүүд, өндөр стандарт, чанартай гүйцэтгэлийг нутагшуулан, оролцогч талуудад үнэ цэнийг бий болгохыг эрхэмлэн ажилладаг. Тус группийн охин компани болох Премиум Индастриал энд Инженеринг ХХК нь 2020 онд Рио Тинто группийн Монгол Улсад хэрэгжүүлж буй Оюу толгой төслийн шилдэг гэрээт компаниар шалгараад байна.



400+
Үндсэн ажилчид



500+
Харилцагч байгууллагууд



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Сэнтрал Экспресс Си Ви Эс компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ) нь хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талууддаа урт хугацааны үнэ цэнийг бий болгох, тэдгээрийн ашиг сонирхолд нийцсэн бодлого, стратегийг тодорхойлж, гүйцэтгэх удирдлагыг компанийн үйл ажиллагааг удирдан явуулахад нь удирдан чиглүүлж, дотоод хяналт, эрсдэлийн удирдлагыг тогтолцоог бүрдүүлэн ажилладаг.



ТУЗ-ИЙН ДАРГА А.ГАНХУЯГ

Туршлага

Премиум Групп ХХК, Үүсгэн байгуулагч
Юнител ХХК, М Си Эс Кока-Кола ХХК, Анунгоо ХХК, Тотал Дистрибьюшн ХХК
ТУЗ-ийн дарга (2012-2017)
М Си Эс Холдинг ХХК, Дэд ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирал, Санхүү хариуцсан захирал (2005-2015)
Монголиан Майнинг Корпорац, Санхүү хариуцсан захирал (2010-2011)

Боловсрол

МУИС, Санхүү, эдийн засгийн бакалавр



ТУЗ-ИЙН ГИШҮҮН А.ГАНБОЛД

Туршлага

Премиум Групп ХХК, Үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал
Нэйшнл Девелопер ХХК, Гүйцэтгэх захирал (2007-2011)
Ганброс ХХК, Үүсгэн байгуулагч, Ерөнхий захирал (2003-2007)

Боловсрол

ОХУ-ын Хот Байгуулалтын Дээд Сургууль, Цахилгаан тээврийн инженер



ТУЗ-ИЙН ГИШҮҮН Г.БАТ-ЭРДЭНЭ

Туршлага

Премиум Групп ХХК, Санхүү хариуцсан дэд ерөнхийлөгч
М Си Эс Энержи ХХК, Дэд захирал (2012-2016)
Энержи Ресурс ХХК, Санхүү хариуцсан дэд ерөнхийлөгч (2008-2012)
М Си Эс Кока-Кола ХХК, Санхүү, төлөвлөлтийн албаны дарга (2003-2007)

Боловсрол

Хан-Уул Дээд Сургууль, Бизнесийн удирдлага, хэрэглээний математик



ТУЗ-ИЙН ГИШҮҮН О.БАТМӨНХ

Туршлага

Премиум Групп ХХК, Дэд ерөнхийлөгч
Премиум Индастриал Инженеринг ХХК, Гүйцэтгэх захирал (2011-одоог хүртэл)
СиПиАй Карт Групп ХХК (АНУ), Чанарын албаны дарга (2005-2009)

Боловсрол

АНУ-ын Үндэсний Их Сургууль, Бизнесийн удирдлага

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ



ТУЗ-ИЙН ГИШҮҮН, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.ЧИНЗОРИГ

Туршлага

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК, Гүйцэтгэх захирал
 Премиум Групп ХХК, Бизнес хөгжлийн газрын захирал (2017-2018)
 МТШХХГ, Инновацын албаны дарга (2014-2016)
 Азийн Хөгжлийн банк, Мэргэжилтэн (2009-2010)

Боловсрол

АНУ-ын Луисвиллийн Их Сургууль, Бизнесийн удирдлагын магистр



Б.ЦЭВЭЛМАА

ҮЙЛ АЖИЛЛАГАА
 ХАРИУЦСАН
 ЗАХИРАЛ



С.ДАШДОРЖ, СФА

САНХҮҮ ХАРИУЦСАН
 ЗАХИРАЛ



Т.БИЛГҮҮН

МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИ
 ХАРИУЦСАН ЗАХИРАЛ



Г.САРАНГЭРЭЛ

ЗАХИРГАА ХҮНИЙ
 НӨӨЦИЙН АЛБАНЫ
 ЗАХИРАЛ



Ч.САРАА

БҮТЭЭГДЭХҮҮН
 ХӨГЖҮҮЛЭЛТИЙН
 АЛБАНЫ ЗАХИРАЛ



Д.НЯМСҮРЭН

БҮТЭЭГДЭХҮҮН
 СОУРСИНГИЙН
 АЛБАНЫ ЗАХИРАЛ



М.ОТГОНТУНГАЛАГ

МАРКЕТИНГ
 СУРТАЛЧИЛГААНЫ
 АЛБАНЫ ЗАХИРАЛ

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Сэнтрал Экспресс Си Ви Эс компани нь СУ конвинеенс сүлжээ дэлгүүрийн бүтээгдэхүүн үйлчилгээг Монгол Улсад нэвтрүүлснээр уламжлалт найман нэрийн хүнсний дэлгүүрийн үйлчилгээг шинэ түвшинд гаргаж, хэрэглэгчид олон улсын стандартад нийцсэн цэвэр цэмцгэр, тохилог орчинд өөрт хэрэгцээт бүтээгдэхүүнийг сонгон үйлчлүүлэх нөхцөлийг бүрдүүлээд байна. Энэ нь Монгол Улсын жижиглэн худалдааны салбарын хөгжлийг урагшлуулсан алхам болсон юм.



Сэнтрал Экспресс нэртэй Монголын хамгийн анхны конвинеенс сүлжээ дэлгүүрийн суурийг тавив.

2015 он



Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийг үүсгэн байгуулав.


2017 он



БНСУ-ийн BGF Retail компанийн мастер франчайз эрхийг Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК хүлээн авав.

Монгол улсын "Анхны ая тухтай" дэлгүүр MNS гэрчилгээ авав.

2018 он



4,200 м² энгийн температурын горимтой түгээлтийн төвийг ашиглалтад оруулав.

Петровис ШТС-үүдэд салбар дэлгүүрүүд нээв.

Монголын ТОП-100 аж ахуйн нэгжийн нэгээр шалгарав.

Монголын хамгийн хурдан 30 минутын дотор хүргүүлэх "CU Хүргэлтийн үйлчилгээ"-г нэвтрүүлэв.

CU салбар дэлгүүрийг франчайзийн эрхээр жижиг дунд бизнес эрхлэгчдэд эзэмшүүлж эхлэв.

Монголын хамгийн анхны 100 салбар дэлгүүртэй сүлжээ болов.

Монголын хамгийн анхны хүнсний аюулгүй байдлын олон улсын GMP, НАССР стандартыг хангасан хоолны үйлдвэрийг байгуулж, ашиглалтад оруулав.




CU апп 320 мянган гишүүнтэй болов.

CU брэнд 127 салбар дэлгүүртэй болов.

CU брэнд НҮБ-ын хүүхдийн сантай хамтран "Байгальд ээлтэй Монгол гэр" төслийг хэрэгжүүлж эхлэв.

ЦЕГ-ын Хүүхэд хамгааллын хэлтэстэй хамтран "CU ЧАМД ТУСАЛЪЯ" төслийг хэрэгжүүлж эхлэв.

Олон нийтэд нээлттэй хувьцаат компани болох ажлыг эхлүүлэв.



CU брэнд 50 салбар дэлгүүртэй болов.

Нэг өдөрт үйлчлүүлэгчдийн тоо 30,000 -д хүрэв.

Монголын хамгийн анхны гар утасны аппликейшнд суурилсан үнэнч хэрэглэгчийн хөтөлбөр CU апп-ийг нэвтрүүлэв.


2019 он

2020 он

2021 он

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОГ, ДАВУУ ТАЛ

Сэнтрал Экспресс Си Ви Эс компани нь CU конвниенс дэлгүүрээр дамжуулан хэрэглэгчдийн өдөр тутмын амьдралд эрэлт хэрэгцээтэй бүтээгдэхүүн, үйлчилгээг хамгийн ойр байрлах ая тухтай орчинд 24 цагийн турш санал болгохыг зорьдог.



Бүтээгдэхүүн үйлчилгээг тасралтгүй хүргэх, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг тогтмол өндөр түвшинд байлгахын тулд Сэнтрал Экспресс Си Ви Эс компани нь бүтээгдэхүүн үйлчилгээний ялгарал, логикийн, технологийн цогц шийдлийг бий болгож, нийгмийн дэд бүтцийн нэг хэсэг болон ажиллаж байна.



Уламжлалт хүнсний дэлгүүр, мухлагтай харьцуулахад CU конвениенс дэлгүүр нь дараах 5 үндсэн онцлог давуу талтай.

- Бүтээгдэхүүн үйлчилгээний ялгарал
- Технологийн цогц шийдэл
- Логистикийн цогц шийдэл
- Нийгмийн дэд бүтэц
- Франчайз хөтөлбөр

БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЯЛГАРАЛ

CU конвениенс дэлгүүр өөрийн нэрийн, үндэсний үйлдвэрлэгчидтэй хамтран хөгжүүлсэн болон импортын шинэлэг тренд бүтээгдэхүүнийг үнийн уян хатан бодлого баримтлан хэрэглэгчдэд санал болгож, олон улсын стандартад нийцсэн үйлчилгээг үзүүлж байна.

Олон улсын стандартад нийцсэн үйлчилгээ



Оновчтой
талбай
ашиглалт



Стандартын
шаардлага
хангасан



Бүрэн
тохижилттой

Хэрэглэгчийн сэтгэл ханамжийг өндөрт байлгаж, үйлчилгээний стандартыг алдагдуулахгүйн тулд дэлгүүрийн стандартын нийцлийн үнэлгээ болон чанарын хяналт, зөрчлийн залруулгын удирдлагын QSC системийг ашигладаг.

Гарт ойр хүргэлтийн үйлчилгээ

Сэнтрал Экспресс Си Ви Эс компани нь 30 минутын дотор хүргэж өгөх хамгийн хурдан хүргэлтийн үйлчилгээг 2020 оны 5 сард нэвтрүүлж 2,000 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг хэрэглэгчид санал болгож, бүх салбар дэлгүүрээр дамжуулан хүргэлтийн үйлчилгээг үзүүлж байна. 2021 оны 6 сарын байдлаар дараах үзүүлэлттэй байна.



Хүргэлт хийдэг
дэлгүүрийн тоо

121



CU апп-ээр хийгдсэн
захиалгын хувь

70%



Хүргэлтийн
захиалгын тоо

780,000



Хүргэлтийн үйлчилгээ
авсан хэрэглэгчийн тоо

124,000



ТЕХНОЛОГИЙН ЦОГЦ ШИЙДЭЛ

Сэнтрал Экспресс Си Ви Эс компани нь өдөр тутмын үйл ажиллагаандаа технологийн дэвшилтэд шийдлийг ашиглан бараа бүтээгдэхүүний оновчтой удирдлагыг хэрэгжүүлэхээс гадна хэрэглэгчийн хувьсан өөрчлөгдөж буй хэрэгцээ шаардлагыг өгөгдөлд суурилсан судалгаа шинжилгээгээр нээн илрүүлж, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг тогтмол хийдэг.

Бараа бүтээгдэхүүний оновчтой удирдлага

VENDOR PORTAL



LS RETAIL



POWER BI



Дэлгүүрийн байршилд тохирсон нийлүүлэлт

Тасралтгүй ханган нийлүүлэлт

Үнийн мэдээлэл солилцох


Урамшуулал

Тооцоо хийх

Бүтээгдэхүүний оновчтой удирдлага

Үнэнч хэрэглэгчийн хөтөлбөр

Үнэнч хэрэглэгчийн хөтөлбөр нь лоялти оноогоор шагнах, худалдан авалтын давтамжид суурилсан урамшуулал олгох, хувь хэрэглэгчийн онцлогт тохирсон бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгох замаар урт хугацаанд хэрэглэгчид хүрэх үнэ цэнийг нэмэгдүүлдэг бөгөөд CU аппликэйшнээр дамжуулан тус хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. 2021 оны 6 сарын байдлаар CU аппликэйшн дараах үзүүлэлттэй ажиллаж байна.



320,000+

CU апп хэрэглэгчийн тоо



Хямдрал урамшуулал

70% хүртэлх

ЛОГИСТИКИЙН ЦОГЦ ШИЙДЭЛ

Түгээлтийн төвүүд

Конвинеенс дэлгүүр нь төвлөрөл ихтэй бүсийн нэгж метр квадрат талбайгаас хамгийн өндөр борлуулалтыг хийхээр зорьдог тул жижиг талбайд үйл ажиллагаа явуулдаг онцлогтой. Иймд бараа бүтээгдэхүүнийг тогтмол нийлүүлэхийн тулд нөөцийн хэмжээ, эргэцийн хурдыг тооцоолсон хяналт, хадгалалт, түгээлт, тээвэрлэлтийг нэгдсэн удирдлагаар хангаж ажилладаг. Түгээлтийн төвүүд нь өдөрт 500 орчим ханган нийлүүлэгчийн 3.5 мянга орчим бараа бүтээгдэхүүнийг хүлээн авч, салбаруудад түгээдэг.



ӨДӨРТ 3-4 УДАА

Нэг дэлгүүрт бараа ханган нийлүүлдэг

Хэвийн температурын горимтой бүтээгдэхүүний түгээлтийн төв

Сэнтрал Экспресс Си Ви Эс компанийн охин компани болох Премиум Дистрибьюшн компани нь Баянгол дүүрэгт 4,200 м² талбайд Хэвийн горимын түгээлтийн төвийг ашиглалтад оруулж, Агуулахын удирдлагын систем (Warehouse Management System)-ээр үйл ажиллагааг удирдан ажиллаж байна.



Хүйтэн хэлхээт түгээлтийн төв

Хүйтэн хэлхээт түгээлтийн төв нь +4°C горим шаарддаг бүтээгдэхүүнийг хадгалах, бэлтгэх, түгээх зориулалт бүхий 375 м² талбайтай, зориулалтын тоног төхөөрөмж, агаар сэлгэлтийн системтэй. Тус төвд СУ хоолны үйлдвэрээс бэлтгэгдэн гарч буй хоолнуудаас гадна дотоодын бусад ханган нийлүүлэгчдийн бүтээгдэхүүнийг хүлээн авч, өдөрт дунджаар 55 мянган ширхэг бүтээгдэхүүнийг бэлтгэн нийт СУ конвинеенс сүлжээ дэлгүүрт түгээж байна.

Олон улсын стандартад нийцсэн хоол үйлдвэрлэл

Сэнтрал Экспресс Си Ви Эс компани нь 2020 оны 11 сард Баянзүрх дүүргийн Хонхор тосгонд 2,960 м² талбайтай CU хоолны үйлдвэрийг ашиглалтад оруулсан. Тус үйлдвэр нь CU конвينيенс дэлгүүрт савласан хоолыг нийлүүлдэг бөгөөд хүнсний аюулгүй байдлын олон улсын Аюулын дүн шинжилгээ ба Эгзэгтэй цэгийн хяналтын (Hazard Analysis Critical Control Point) болон Үйлдвэрлэлийн зохистой дадлын (Good Manufacturing Practice) тогтолцооны болзлыг хангасан Монголын анхны нэг чиглэлийн урсгалтай нийтийн хоолны үйлдвэр юм.



Тус хоолны үйлдвэр нь өдөр бүр 20 гаруй нэр төрлийн 8 мянган ширхэг хоолыг хүнсний хугацаа уртасгагч, тогтворжуулагч бодисгүйгээр үйлдвэрлэж байна. Мөн жижиг дунд бизнес эрхлэгчдэд CU хоолны үйлдвэрийн дэд бүтэц, ажиллах хүчинд түшиглэн бүтээгдэхүүн хөгжүүлэх, CU конвينيенс дэлгүүрээр борлуулах боломжийг нээсэн билээ. Тус үйлдвэрийн барилгын давуу тал нь хүнсний үйлдвэр болон хөргөх өрөөг зориулалтын EPS, полиуретан хавтангаар дугуй булан гарган хийсэн нь нян бактери үржихгүй байх нөхцөлийг бүрдүүлсэнд оршдог.

НИЙГМИЙН ДЭД БҮТЭЦ

Конвينيенс дэлгүүр нь хэрэглэгчид хамгийн ойр байдаг үйлчилгээний дэд бүтцийн үүргийг гүйцэтгэдэг. CU конвينيенс сүлжээ дэлгүүр нь зөвхөн бараа бүтээгдэхүүн борлуулахаас гадна хэвлэлийн үйлчилгээ, шуудангийн үйлчилгээ зэрэг хэрэглэгчийн хувьсан өөрчлөгдөж буй амьдралын хэв маягт нийцсэн бусад үйлчилгээг хэрэглэгчид нэг цэгээс 24 цагийн турш хүргэх боломжийг бүрдүүлж байна.



Үнэгүй
интернэт




Хүүхэд
хамгаалал




Ариун цэврийн
өрөө

Хамгийн хүртээмжтэй үйлчилгээ

CU конвينيенс дэлгүүр нь хэрэглэгчид хамгийн ойр буюу орон сууцны хороолол, оффис, эмнэлэг, сургууль, автобусны буудал, нисэх буудал, автовокзал зэрэг хүн амын хөдөлгөөний урсгал ихтэй байршлуудад нэвтэрсэн нь Улаанбаатар хотын хамгийн өргөн хүрээний дэд бүтцийг бий болгож байна.



Салбартаа тэргүүлэгч компаниудын УБ хот дахь салбарын тоо



ФРАНЧАЙЗ ХӨТӨЛБӨР

Сэнтрал Экспресс Си Ви Эс компани нь мастер франчайз эрх эзэмшлийн хүрээнд доороо франчайз дэлгүүрүүд үүсгэх эрхтэй. Өөрөөр хэлбэл дэлгүүр, жижиглэн худалдааны салбарын бизнес эрхлэгчид CU нэрийн дор багтан мэдээлэл, логистик, технологи, менежментийн цогц шийдлийг ашиглах боломжтой юм. Франчайз эрх эзэмшигчдэд зориулсан хүний нөөц, мэдээлэл технологийн систем, агуулахын менежмент зэрэг чиглэлээр сургалт зохион байгуулж, нэгдсэн стандарт хэвшүүлэх замаар дэлгүүрийн цар хүрээг тэлэх, бизнес эрхлэгчдэд урт хугацаатай, бизнесийн шийдлийг олгон харилцан ашигтай хамтран ажилладаг.



БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭ

Сэнтрал Экспресс Си Ви Эс компани нь бизнесийн тогтвортой хөгжлийг эрхэмлэн, нээлттэй компани болгохтой холбогдуулж салбартаа анх удаа сүлжээ дэлгүүрүүд, нэгдсэн түгээлтийн төв, хоолны үйлдвэр гэсэн үйл ажиллагааны бүх шатанд байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын суурь үнэлгээг хийлгэсэн юм. Олон Улсын Санхүүгийн Корпорацын Байгаль орчны болон нийгмийн гүйцэтгэлийн стандарт, конвенц, тунхаглал болон Монгол Улсын холбогдох хууль, стандарт, журамд заасан 182 шалгуур үзүүлэлтийг суурь үнэлгээ болгон авч үзсэн бөгөөд үүнээс Сэнтрал Экспресс Си Ви Эс компани нь нийт 174 шалгуурыг бүрэн хангаж 95.6 хувийн биелэлттэй гарсан нь сайшаалтай.

СУ Чамд тусалъя



Монгол Гэр Төсөл



Сэнтрал Экспресс Си Ви Эс компани нь Нийслэлийн Цагдаагийн Ерөнхий Газрын Гэр Бүлийн Хүчирхийлэл, Хүүхдийн Эсрэг Гэмт Хэрэгтэй Тэмцэх Газартай хамтран хүүхэд хамгааллын СУ ЧАМД ТУСАЛЪЯ төсөл, П.Н.Шастины нэрэмжит Улсын Гуравдугаар Төв Эмнэлгийн Мэдрэл болон Зүрхний мэс заслын тасгийн хүлээлгийн танхимын тохижуулалт, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан хамтран Монгол Гэр төсөл зэрэг олон төсөлт хөтөлбөрийг нийгмийн хариуцлагын хүрээнд санаачилж хэрэгжүүлсэн.

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЗАХ ЗЭЭЛ БА СТРАТЕГИ

Олон улсын конвинеенс дэлгүүрийн зах зээл


Олон улсын конвинеенс дэлгүүрийн зах зээл нь 3 их наяд гаруй ам.доллараар хэмжигдэж байна. Улс орнуудын конвинеенс дэлгүүрийн зах зээлийн өсөлт нь эдийн засгийн өсөлт, хотжилттой шууд хамааралтай тул БНХАУ зэрэг хурдацтай хөгжиж буй орнуудад конвинеенс дэлгүүрийн зах зээл өндөр өсөлттэй байна. Харьцангуй тогтворжсон зах зээлд буюу Япон улсад конвинеенс дэлгүүрийн салбарын орлого жилд дунджаар 2-4 хувиар өсөж, 12.2 их наяд иен буюу 314.15 их наяд төгрөгөөр, Тайван улсад конвинеенс дэлгүүрийн салбарын орлого жилд дунджаар 3-6 хувиар тогтвортой өсөж байна.

Харин зах зээлийн өсөлтийн үе шатаас тогтворжилтын үе шат руу шилжиж буй БНСУ-д 2020 оны байдлаар салбарын орлого 26.5 их наяд вон буюу 60.95 их наяд төгрөгт хүрсэн байна. Тус зах зээлд БНСУ-ын БиЖиЭф Ритэйл (CU brand) болон ЖиЭс Ритэйл (GS Retail, GS25 brand) компаниуд тус бүр 15 мянга орчим салбартайгаар зах зээлд тэргүүлдэг.

Доорх хүснэгтэд улс орнуудын конвинеенс дэлгүүрүүдийн орлогын өсөлтийг харуулав.

	2016	2017	2018	2019	Дундаж
БНСУ	18.4%	14.2%	9.8%	5.2%	11.9%
Индонези	12.5%	11.1%	10.0%	9.1%	10.7%
Тайван	0.0%	2.8%	6.3%	2.8%	3.8%
Япон	4.1%	2.6%	2.0%	1.7%	2.6%

Конвинеенс дэлгүүрийн зах зээл Япон улсад 1970, Тайван улсад 1980, БНСУ-д 1990, Индонези улсад 2010-аад оноос хойш тус тус хөгжин 10-50 жилийн турш оршин тогтнож буй ч өсөлтөө хадгалсаар байна.




Аливаа салбарын амьдралын мөчлөг нь хөгжлийн, өсөлтийн, тогтворжилтын болон уналтын гэсэн дөрвөн үе шаттай байдаг ч конвинеенс дэлгүүрийн салбарт тогтворжих үе шат үргэлжилсээр байгаа нь энэхүү бизнес нь амьдралын урт мөчлөгтэй болохыг харуулж байна.


МОНГОЛ УЛСЫН КОНВИНИЕНС ДЭЛГҮҮРИЙН ЗАХ ЗЭЭЛ

Сэнтрал Экспресс Си Ви Эс компани нь Монгол Улсын анхны конвiniенс дэлгүүрийг 2017 онд байгуулсан. Өдгөө жижиглэн худалдааны салбарт конвiniенс дэлгүүрийн зах зээл нь хамгийн хурдтай өсөж байна.

Конвiniенс дэлгүүрийн үүсэл хөгжлөөс харвал Япон, БНСУ-ын зах зээлд богино хугацаанд олон шинэ конвiniенс дэлгүүрийн брэндүүд нэвтэрч, зах зээлд байр сууриа олохын төлөөх ширүүн өрсөлдөөн өрнөсөн түүхтэй. Монгол Улсын конвiniенс дэлгүүрийн зах зээлд ч мөн адил энэ түүх давтагдахаар харагдаж байна.



Конвiniенс дэлгүүрийн салбарын тоо




2021 оны эхний 6 сарын байдлаар Улаанбаатар хотод нийт 5 брэндийн 172 конвiniенс дэлгүүр үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс Сэнтрал Экспресс Си Ви Эс компанийн мастер франчайзийн эрхээр эзэмшиж буй CU конвiniенс сүлжээ дэлгүүр 2018 оноос тасралтгүй өсөж 127 салбар дэлгүүрийг шинээр нээсэн байна. Үүний дараа Circle K брэнд 22, Ecoexpress брэнд 12, Vpoint брэнд 0, GS25 брэнд 11 салбартайгаар үйл ажиллагаа явуулж байна.

ЗАХ ЗЭЭЛИЙН БАГТААМЖ

Улаанбаатар хотын конвiniенс дэлгүүрийн зах зээлийн багтаамжийг орлого болон өрхийн хэрэглээнд суурилсан болон хүн амын нягтаршилд суурилсан аргаар тус тус тооцсон.


Орлого болон өрхийн хэрэглээнд суурилсан багтаамж

Худалдааны салбар нь эдийн засгийн нөхцөл байдал, хүн амын худалдан авах чадвараас шууд хамааралтай. Иймд Сэнтрал Экспресс Си Ви Эс компанийн үйл ажиллагаа явуулж буй зах зээлийг орлогод болон өрхийн хэрэглээнд суурилсан аргаар эдийн засгийн өсөлтөөс хамааруулан тооцоход 2020 оны байдлаар Улаанбаатар хотын жижиглэн худалдааны зах зээл 12.6 их наяд төгрөгөөр хэмжигдэж, 2026 онд 23.9 их наяд төгрөгт хүрэх төлөвтэй байна. 2020 онд Сэнтрал Экспресс компани нь 45.3 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан нь зах зээлийн 0.4 хувийг эзэлж байна.




Конвiniенс дэлгүүрийн зах зээлд эзлэх хувь

Конвiniенс дэлгүүрийн хувьд хөгжингүй орнуудад жижиглэн худалдааны салбарынхаа 15 хувийг, хөгжиж буй орнуудын хувьд 3 хувийг эзэлдэг. Харин Монгол улсын хувьд конвiniенс дэлгүүрийн салбар нь жижиглэн худалдааны салбарын 1 хувийг бүрдүүлж байна. Олон улсын жишгээс харвал Монгол улсад конвiniенс дэлгүүрийн зах зээл өсөх орон зай өндөр байна.




Хүн амын нягтаршилд суурилсан багтаамж

2021 оны хагас жилийн байдлаар Улаанбаатар хотод нэг конвiniенс дэлгүүрт 8,294 хүн ногдож байна. Бусад Азийн орнуудын жишгээс харахад 2012 оны байдлаар нэг конвiniенс дэлгүүрт дунджаар 2,340 хүн ногдож байсан бол 2018 онд 1,891 болжээ. Энэ нь манай улсад нэг хүнд ногдох конвiniенс дэлгүүрийн тоо олон улсын жишгээр маш бага байгааг харуулж байна.



Конвiniенс дэлгүүрийн тоон багтаамж

Улаанбаатар хотын Багахангай, Багануур, Налайх дүүргийн хүн амыг хасаж тооцсон 1,426,645 хүн амыг дээрх үзүүлэлттэй харьцуулан тооцоход зах зээлийн багтаамж 754 дэлгүүр байна. Цаашид Сэнтрал Экспресс Си Ви Эс компани нь тус багтаамжийн 48 орчим хувийг эзлэх төлөвлөгөөтэй байна.




САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД


Сэнтрал Экспресс Си Ви Эс компанийн орлого нь 2018-2020 оны хооронд жилд дунджаар 182 хувиар, харин 2021 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 84 хувиар тус тус өсжээ. Татварын дараах алдагдал нь 2020 оны эхний хагаст 8.1 тэрбум төгрөгт хүрсэн бол 2021 оны эхний хагаст 7.2 тэрбум төгрөгт хүрчээ. 2021 оны хагас жилийн байдлаар нийт хөрөнгийн хэмжээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 94.9 хувиар өсөж, өр төлбөрийн хэмжээ 21.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Борлуулалтын орлого (сая төгрөгөөр)

2018-2020
Жилийн дундаж өсөлт: 182%




Татварын дараах ашиг, алдагдал (сая төгрөгөөр)




Нийт хөрөнгө (сая төгрөгөөр)

2018-2020
Жилийн дундаж өсөлт: 120%



Нийт эздийн өмч (сая төгрөгөөр)



Ковид-19 дараах борлуулалтын сэргэлт

Ковид-19 цар тахлаас үүдэлтэйгээр Сэнтрал Экспресс Си Ви Эс компанийн борлуулалтын орлого 2020 оны 1 сараас эхлэн буурсан. Харин 2021 оны 4 сараас цар тахлын нөлөө буурч сэргэлт эхэлсэн 5, 6 сарын борлуулалт 2.5 сая төгрөг болж өссөн нь цаашид борлуулалт тогтвортой өсөх боломжтойг илтгэж байна.



САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Иж бүрэн логистик, мэдээллийн системийн шийдэл, бэлтгэн нийлүүлэгчид, үйлчилгээний байгууллагуудтай хамтарсан шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх боломж улам өргөсч байгаа, дэлгүүрийн тоог нэмэгдүүлэх зах зээлийн багтаамж, түүнд хүрэх стратеги байгаа нь Сэнтрал Экспресс Си Ви Эс компанийн борлуулалтын орон зайг нэмэгдүүлэх суурь хүчин зүйлийг бий болгож байгаа бөгөөд 2023 онд 390 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой, 7.7 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллах төлөвлөгөөтэй байна.

Нэгж дэлгүүрийн өдрийн дундаж борлуулалт (сая төгрөгөөр)




Нийт дэлгүүрийн тоо




Борлуулалтын орлого (тэрбум төгрөгөөр)

2021-2030
Жилийн дундаж өсөлт: 26%



Цэвэр ашиг (тэрбум төгрөгөөр)

2023-2030
Жилийн дундаж өсөлт: 39%




Нийт хөрөнгө (тэрбум төгрөгөөр)

2021-2030
Жилийн дундаж өсөлт: 17%



Цэвэр мөнгөн гүйлгээ (тэрбум төгрөгөөр)

2021-2030
Жилийн дундаж өсөлт: 38%



БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ, ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ

Сэнтрал Экспресс Си Ви Эс компани нь хэрэглэгчидтэй илүү ойр байршиж, илүү хялбар, ухаалаг бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэхээр зорьж байна. Энэхүү зорилтдоо хүрэхийн тулд дараах 5 стратегийг дунд хугацаанд хэрэгжүүлнэ.



ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Их Дунд Бага	Нөлөө	Их	Бараа бүтээгдэхүүний тасалдал Брэндийн нэр хүнд Хөрвөх чадварын эрсдэл Ковид-19 хатуу хөл хорио	Ковид-19 онцгой дэглэм буурахгүй байх эрсдэл	
		Дунд	Мэдээллийн технологийн системийн доголдол Түрээсийн төлбөр нэмэгдэх эрсдэл	Бүтээгдэхүүний сонголт, хөгжүүлэлтийн эрсдэл Франчайзтай үүсэх зөрчил Хүний нөөцийн эрсдэл Хууль, зохицуулалтын эрсдэл	Өрсөлдөөний эрсдэл
		Бага	Эдийн засгийн хэлбэлзлийн эрсдэл	Валютын ханшийн эрсдэл	Инфляцын эрсдэл
			Магадлал		
			Бага	Дунд	Их

Сэнтрал Экспресс Си Ви Эс компанийн бизнесийн үйл ажиллагааны цар хүрээ томорч буйтай холбоотойгоор ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын менежментийн баг нь учирч болох эрсдэлүүдийг тасралтгүй тодорхойлох, бууруулах, арилгахын тулд богино ба дунд хугацааны арга хэмжээг тогтмол авч, урт хугацааны стратегийн шийдвэр гаргалтуудад гол эрсдэлүүдийг харгалзах зэргээр эрсдэлийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлж ирсэн. Сэнтрал Экспресс Си Ви Эс компанийн үйл ажиллагаанд учирч болзошгүй голлох 4 эрсдэлийг дараах байдалтай байна

Өрсөлдөөний эрсдэл	Бараа нийлүүлэлтийн тасалдлын эрсдэл
Жижиглэн худалдааны зах зээл өрсөлдөөн ихтэй тул ойролцоо байршил дахь хүнсний дэлгүүр, конвинеенс дэлгүүрийн тоо нэмэгдсэнээр нэгж дэлгүүрийн болон дундаж борлуулалт буурах, хэрэглэгчдийн тоо хуваагдах эрсдэлтэй. Сэнтрал Экспресс Си Ви Эс компани нь зах зээлд давамгайлах стратегийг хэрэгжүүлж, хүн амын хөдөлгөөний урсгал байршлуудад түргэн байршиж, өөр хоорондоо оновчтой зайтайгаар буюу 150-200 метрийн зайд конвинеенс дэлгүүрийг тэлснээр өрсөлдөөнд давуу байдлыг бий болгож, тус эрсдэлийг бууруулна.	Бэлтгэн нийлүүлэгч нь бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийг захиалгын дагуу гүйцэтгэхгүй байх, тасалдал үүсэх, бэлэн байдал алдагдсанаар борлуулалтын орлого тасалдах эрсдэлтэй. Сэнтрал Экспресс Си Ви Эс компани нь өөрийн нэгдсэн түгээлтийн төвөөр дамжуулан CU конвинеенс сүлжээ дэлгүүрийн системийн хэмжээний бараа бүтээгдэхүүний удирдлагыг нэгдсэн сувгаар хангаж, бараа бүтээгдэхүүний нөөцийг үүсгэх, тус нөөцөөс дэлгүүр бүрийн захиалгад тулгуурласан тасалдалгүй нийлүүлэлтийг гүйцэтгэх замаар тус эрсдэлийг бууруулдаг.
Ковид-19 эрсдэл	Нэр хүндийн эрсдэл
Ковид-19 цар тахлаас үүдэлтэйгээр үйлчилгээний байгууллагын ажиллах цагийн хуваарь, горим, хэрэглэгчийн тоонд хязгаарлалт тавьснаар борлуулалт буурах эрсдэлтэй. Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь нь Монгол улсын хамгийн хурдан хүргэлтийн үйлчилгээг амжилттай нэвтрүүлсэн бөгөөд цаашид хүргэлтийн үйлчилгээг өргөжүүлснээр Ковид-19 цар тахлаас үүдэлтэй хязгаарлалт, тэдгээрийн борлуулалтад үзүүлэх нөлөөг бууруулах боломжтой.	Олон улсын франчайз эрх эзэмшиж буйн хувьд үйлчилгээний стандарт алдагдаж брэндийн нэр хүнд унах, харилцагчдын итгэлийг алдах нэр хүндийн эрсдэл үүсэх магадлалтай. Нэр хүндийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор Сэнтрал Экспресс Си Ви Эс компани нь хэрэглэгчтэй шууд харилцдаг дэлгүүрийн ажилтнуудад QSC үйлчилгээний стандартын сургалтыг тогтмол явуулж, хэрэглэгчийн гомдол, саналыг нээлттэй хүлээн авах, барагдуулах харилцагчийн үйлчилгээний төвийг ажиллуулдаг.





ТАВТАЙ МОРИЛ

ҮНЭТ ЦААСНЫ
ТУХАЙ

СУ-ГИЙН ХУВЬЦАА ЮУГААРАА ОНЦЛОГ ВЭ?

Өсөлтийн өндөр боломжтой, тогтвортой үнэт цаас

Өсөлтийн үе шат нь ид өрнөж буй компани тул зах зээлийн дунджаас өндөр өсөлт үзүүлэх боломжтой

Урт хугацаан дахь тогтвортой ногдол ашиг

Өрийн хөшүүрэг бага, чөлөөт мөнгөн урсгал өндөр тул урт хугацаанд тогтвортой ногдол ашиг тараах боломжтой

Хямдруулсан үнэлгээтэй хувьцаа

Үнэлгээнээс 21.5 хувийн хөнгөлөлттэй үнээр нийтэд санал болгоно

Үнэ тогтворжуулах хөтөлбөр

Хувьцааны үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор үнэ тогтворжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ

Санхүүжилтийн баталгаа

Нийт татан төвлөрүүлэх санхүүжилтийн 48 хувийн баталгааг андеррайтерууд гаргасан

ҮНЭ ТОГТООСОН ҮНДЭСЛЭЛ

ҮНЭЛГЭЭ
211.8 ТЭРБУМ ТӨГРӨГ



ХЯМДРУУЛСАН
ҮНЭЛГЭЭ (21.5%)
166.4 ТЭРБУМ ТӨГРӨГ

НЭГЖ ХУВЬЦААНЫ ҮНЭ
265 ТӨГРӨГ



НЭГЖ ХУВЬЦААНЫ
ҮНЭ
208 ТӨГРӨГ

Үнэт цаасны зах зээлд оролцогч этгээдэд үйлчилгээ үзүүлэх эрх бүхий хөндлөнгийн үнэлгээний байгууллага болох Гэрэгэ Эстимэйт ХХК нь Сэнтрал Экспресс Си Ви Эс компанийн хараат бус бизнесийн үнэлгээг хорогдуулсан мөнгөн гүйлгээний аргаар хийж гүйцэтгэсэн.

Компанийн зах зээлд эзлэх байр суурь, өсөлтийн хурд, бий болгосон дэд бүтэц, зах зээлийн багтаамжийг харгалзан үзэн 2023 он гэхэд компани 360 дэлгүүртэй байх боломжтой гэж тооцсон. Үйл ажиллагаа явуулж буй салбарын онцлогтой холбоотойгоор дэлгүүрийн тоо өсөх тусам борлуулалт нэмэгдэхийн сацуу борлуулсан бүтээгдэхүүний өртөг буурах буюу ханган нийлүүлэгчидтэй хэлцэл хийх, бараа бүтээгдэхүүнийг хямдралтай үнээр худалдан авах боломжууд нээгддэг. Мөн өөрийн сувгаар гаргаж буй хоол, хөгжүүлж буй бүтээгдэхүүний нэгж өртөг буурах боломжтой.

Үндсэн тус хүчин зүйлсээс хамаарч өртөг буурснаар одоогоор борлуулалтын зардлыг нийт борлуулалттай харьцуулахад 103% байгааг тогтмол бууруулж 2030 онд гэхэд 82-83% болохоор тооцоолж, түүнээс үүдэн компанийн цэвэр ашиг өндөр өсөлттэй байх боломжтой гэж төсөөлсөн. Борлуулалт өсч, өртөг буурснаар цэвэр ашиг өсөх үндэслэлээр компанийн мөнгөн урсгалын төсөөлөл эерэг, өсөлттэй байхаар тооцон, бизнесийн эцсийн үнэ цэнийг мөн гаргасан. Түүнээс тохирох хорогдуулалтын хувь ашиглан хорогдуулж 2021 оны 6 сарын байдлаар компанийн үнэлгээг 211.8 тэрбум төгрөг гэж үнэлэв. Төсөөллийг 10 жилээр гаргасан ба өнөөгийн үнэ цэнийг гаргахын тулд капиталын жигнэсэн дундаж өртгийг (WACC) 18 хувиар тооцсон.

Сэнтрал Экспресс Си Ви Эс компани болон Андеррайтеруудын зүгээс зах зээлийн өнөөгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж Сэнтрал Экспресс Си Ви Эс компанийн ТУЗ-ийн 2021 оны 7 сарын 26-ны өдрийн 11 тоот тогтоол, 2021 оны 9 сарын 9-ний өдрийн 151021-13 тоот тогтоолыг тус тус үндэслэн нэгж хувьцааны үнийг 208 төгрөг буюу 21.5 хувийн хөнгөлөлттэй үнээр нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн.

ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

Сэнтрал Экспресс Си Ви Эс компани нь 2023 он хүртэлх бизнес төлөвлөгөөний хүрээнд Улаанбаатар хот болон ойролцоох бүсэд нийт 360 конвинеенс дэлгүүрийг бий болгох зорилт тавин ажиллаж байна. Сэнтрал Экспресс Си Ви Эс компани нь олон нийтээс татан төвлөрүүлэх 24.9 тэрбум төгрөгийг дараах зориулалтаар зарцуулахаар төлөвлөж байна.



Нэмэлт дэлгүүрийн хөрөнгө оруулалт (19.0 тэрбум төгрөгөөр)

Нэгж дэлгүүрийн хөрөнгө оруулалт нь одоогийн 127 дэлгүүрийн хувьд талбайн хэмжээнээс хамаарч 110-400 сая төгрөгийн хооронд дунджаар 200 сая төгрөгийн төртөгтэй байна. Олон нийтээс татан төвлөрүүлэх хөрөнгийн 76 хувь болох 19.0 тэрбум төгрөгөөр СИ конвинеенс дэлгүүрийг өргөтгөж, шинээр 95 дэлгүүрийг нээнэ.

Түгээлтийн төвийн нэмэлт тоног төхөөрөмж (2.9 тэрбум төгрөгөөр)

Бараа бүтээгдэхүүний ханган нийлүүлэлтийг тасалдалгүй, оновчтой удирдан зохион байгуулахын тулд түгээлтийн төвийн үйл ажиллагаа нь илүү хялбар, автомат, хүчин чадал сайтай болох шаардлагатай. Иймд татан төвлөрүүлэх дүнгийн 12 хувийг буюу 2.9 тэрбум төгрөгийг тус хэсэгт зарцуулна.

Хоол үйлдвэрлэлийн нэмэлт тоног төхөөрөмж (3.0 тэрбум төгрөгөөр)

Хоолны үйлдвэрт шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх зориулалттай тоног төхөөрөмж болон дэлгүүрийн өргөтгөлтэй уялдаатай нэмэлт тоног төхөөрөмж худалдан авахад 3.0 тэрбум төгрөгийг зарцуулна.

Дээрх хөрөнгө оруулалтуудыг хийснээр хурдацтай өсөж буй СИ конвинеенс сүлжээ дэлгүүр нь өөрийн байр суурийг хадгалах, өндөр өсөлт бий болгох зорилтод хүрэх суурь нөхцөл бүрдэнэ.

Тодруулга: Үнэт цаасны эрэлт нийлүүлэлтээс давсан тохиолдолд Сэнтрал Экспресс Си Ви Эс компанийн шийдвэрээр нийтэд санал болгосон хувьцааны 15 хувь буюу 17,994,909 ширхэг хүртэлх хувьцааг нэмж гарган, 28.7 тэрбум төгрөг хүртэлх хөрөнгийг татан төвлөрүүлнэ.

ХУВЬЦААНЫ ГОЛЛОХ ОНЦЛОГУУД

Санхүүжилтийн баталгаа (firm commitment)

Сэнтрал Экспресс Си Ви Эс компанийн нийтэд хувьцааг анх удаа санал болгох хүрээнд татан төвлөрүүлэх 24.9 тэрбум төгрөгөөс Үндсэн андеррайтер болох Голомт Капитал ҮЦК нь 10 тэрбум төгрөгийг, Туслах андеррайтер болох Апекс Капитал ҮЦК нь 2 тэрбум төгрөгийн санхүүжилтыг хариуцах баталгаа буюу firm commitment гаргасан. Улмаар нийт татан төвлөрүүлэх хөрөнгийн 48 хувийг андеррайтерууд дангаар хариуцах үүрэг хүлээсэн.

Golomt Capital
Delivering diversity

+

APEX
 CAPITAL

=

12
тэрбум төгрөг

Үнэ тогтворжуулах хөтөлбөр

Сэнтрал Экспресс Си Ви Эс компанийн гаргасан энгийн хувьцааг хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны үнийн хэт бууралтаас хамгаалах, хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, тогтвортой байдлыг хангах зорилгоор Сэнтрал Экспресс Си Ви Эс компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох А.Ганхуягтай 3 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий хувьцааны үнэ тогтворжуулах гэрээг байгуулсан.



3 тэрбум төгрөг





СЭНТРАЛ ЭКСПРЕСС КОМПАНИЙН

ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНД ХЭРХЭН ОРОЛЦОХ ВЭ?

ХУВЬЦАА ХУДАЛДАН АВАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИД ДАРААХ ЗААВРЫН ДАГУУ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНД ОРОЛЦОНО.



ҮНЭТ ЦААСНЫ ДАНС НЭЭЛГЭХ
Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй үнэт цаасны компаниудаас сонгож, үнэт цаасны данс нээлгэнэ.
(Иргэний үнэмлэх, дансны хураамж)

1

ЗАХИАЛГА ӨГӨХ

Өөрийн сонгон үйлчлүүлж буй үнэт цаасны компанидаа хувьцаа худалдан авах захиалга өгнө.



2

3



МӨНГӨ БАЙРШУУЛАХ

Үнэт цаасны дансанд доорх зааврын дагуу мөнгөн дүнг арилжааны шимтгэлийн хамт байршуулна.

4

БАЯР ХҮРГЭЭ

Та сэнтрал экспресс компанийн хөрөнгө оруулагч боллоо



Дансны нэр:	Харилцагчийн нэр
Дансны дугаар:	**** * /Брокероос авах/
Банкны нэр:	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК
Гүйлгээний утга:	Нэр, Регистер, CU IPO

Захиалга өгөх:

Голомт Капитал ҮЦК 7012-1530
Алекс Капитал ҮЦК 7510-7500



ТАВТАЙ МОРИЛ

ХАВСРАЛТ

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Орлогын тайлан (сая төгрөгөөр)	2018	2019	2020	2021. II
Борлуулалтын орлого	5,687	37,468	45,348	32,457
Борлуулалтын өртөг	(7,335)	(43,356)	(50,707)	(36,255)
Нийт ашиг, алдагдал	(1,648)	(5,888)	(5,359)	(3,798)
Ерөнхий ба удирдлагын зардал	(2,012)	(4,190)	(5,102)	(2,703)
Үйл ажиллагааны бусад орлого, зардал	(2,269)	1,988	(34)	343
Үйл ажиллагааны ашиг, алдагдал	(5,929)	(8,090)	(10,495)	(6,158)
Санхүүгийн орлого	4	7	159	192
Санхүүгийн зардал	-	(3,191)	(5,588)	(2,481)
Татварын өмнөх ашиг, алдагдал	(5,925)	(11,274)	(15,924)	(8,447)
Орлогын албан татварын хөнгөлөлт, (зардал)	(0)	(1)	196	1,254
Татварын дараах ашиг, алдагдал	(5,926)	(11,275)	(15,728)	(7,192)

Санхүүгийн байдлын тайлан (сая төгрөгөөр)	2018	2019	2020	2021. II
Эргэлтийн бус хөрөнгө				
Үндсэн хөрөнгө	5,685	13,613	17,916	33,115
Ашиглах эрхтэй хөрөнгө	-	15,617	16,813	19,033
Биет бус хөрөнгө	2,468	2,913	2,808	2,897
Бусад хөрөнгө	460	384	3,078	9,161
Эргэлтийн хөрөнгө				
Бараа материал	2,507	4,025	6,711	7,475
Бусад эргэлтийн хөрөнгө	430	1,725	3,486	4,648
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	188	652	6,104	3,962
НИЙТ ХӨРӨНГӨ	11,737	38,929	56,917	80,292
Хувьцаат капитал	10,951	17,145	17,145	67,981
Хуримтлагдсан ашиг	(6,522)	(17,797)	(33,525)	(40,718)
НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ	4,428	(652)	(16,380)	27,263
Урт хугацаат өр төлбөр				
Урт хугацаат түрээсийн төлбөр	-	15,321	19,571	24,334
Урт хугацаат зээл	-	12,551	10,520	12,570
Урт хугацаат санхүүгийн өглөг	2,038	-	-	-
Богино хугацаат өр төлбөр				
Дансны болон бусад өглөг	5,271	7,422	25,218	14,725
Богино хугацаат өр төлбөр	-	3,282	16,361	103
Богино хугацаат түрээсийн төлбөр	-	1,005	1,628	1,293
НИЙТ ӨР ТӨЛБӨР	7,309	39,581	73,297	53,029

САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Орлогын тайлан (тэрбум төгрөгөөр)	2021Т	2022Т	2023Т	2024Т	2025Т	2026Т	2027Т	2028Т	2029Т	2030Т
Борлуулалтын орлого	89	238	390	475	518	561	595	631	669	709
Борлуулалтын өртөг	(95)	(230)	(357)	(424)	(450)	(476)	(503)	(531)	(560)	(591)
НИЙТ АШИГ, АЛДАГДАЛ	(6)	8	33	51	68	86	92	100	109	118
Ерөнхий ба удирдлагын зардал	(7)	(10)	(11)	(11)	(12)	(12)	(13)	(13)	(14)	(14)
Үйл ажиллагааны ашиг, алдагдал	(13)	(2)	22	40	57	74	80	87	96	104
Цэвэр санхүүгийн зардал	(2)	(2)	(2)	(2)	(2)	(1)	(1)	(0)	-	-
Түрээсийн хүүгийн зардал	(5)	(9)	(12)	(14)	(13)	(12)	(12)	(10)	(8)	(8)
Татварын өмнөх ашиг, алдагдал	(20)	(12)	10	26	44	62	68	77	87	96
Орлогын албан татварын хөнгөлөлт, (зардал)	(0)	-	(1)	(3)	(7)	(14)	(16)	(17)	(19)	(21)
Татварын дараах ашиг, алдагдал	(20)	(12)	8	22	35	47	52	59	68	76

Санхүүгийн байдлын тайлан (тэрбум төгрөгөөр)	2021Т	2022Т	2023Т	2024Т	2025Т	2026Т	2027Т	2028Т	2029Т	2030Т
Эргэлтийн бус хөрөнгө										
Үндсэн хөрөнгө	44	61	67	57	50	45	41	37	31	28
Ашиглах эрхтэй хөрөнгө	39	57	67	66	56	47	46	35	26	28
Биет бус хөрөнгө	3	3	3	3	2	2	2	1	1	1
Бусад хөрөнгө	4	4	4	3	3	3	3	3	3	3
Эргэлтийн хөрөнгө										
Бараа материал	10	16	13	13	14	15	16	16	17	18
Бусад эргэлтийн хөрөнгө	7	6	6	5	5	5	5	5	5	5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	11	2	17	48	87	133	183	244	316	390
НИЙТ ХӨРӨНГӨ	117	149	176	196	218	249	294	342	399	472
Хувьцаат капитал	91	91	91	91	91	91	91	91	91	91
Хуримтлагдсан ашиг	(52)	(64)	(57)	(35)	1	48	100	159	227	303
НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ	39	27	35	57	92	139	191	250	319	394
Урт хугацаат өр төлбөр										
Урт хугацаат түрээсийн төлбөр	42	63	77	80	74	66	67	56	43	38
Урт хугацаат зээл	17	25	22	18	14	9	3	0	0	0
Богино хугацаат өр төлбөр										
Дансны болон бусад өглөг	20	32	39	37	34	30	29	30	32	34
НӨАТ-ын өглөг	-	2	3	4	4	5	5	5	6	6
НИЙТ ӨР ТӨЛБӨР	78	122	141	139	126	110	104	91	81	78



ТАВТАЙ МОРИЛ

Үнэт цаас гаргагч



- +976 77330101
- www.cumongol.mn
- info@cumongol.mn
- СБД, 1-р хороо, ЮНЕСКО-ийн гудамж, Далай Тауэр, 11 давхар

Үндсэн андеррайтер



- +976 70121530
- www.golomtcapital.com
- info@golomtcapital.com
- СБД, Чингисийн өргөн чөлөө, Парк Плэйс, 4 давхарт, 403 тоот

Туслах андеррайтер



- +976 75107500
- www.apex.mn
- Investment@apex.mn
- СБД, 1-р хороо, Олимпийн гудамж, Нью Хорайзонс оффис, 9 давхар, 901 тоот